



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/362

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн түүхийн сонсдог ном бүтээх ажлын уншилтын эх хэрэглэгдэхүүн бэлтгэх ажлыг 10,000,000 (арван сая) төгрөгөөр түүхийн ухааны доктор Н.Батболдтой гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг түүхийн ухааны доктор (Н.Батболд)-д даалгасугай.

3. Санхүүжилтийг аймгийн Засаг даргын “Бүх нийтийн соёлын боловсрол олгох хөтөлбөр төлөвлөгөө”-ний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

